

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Тогтвортой нийгэм, ирээдүйг бүтээхэд жендэрийн тэгш байдлыг хангах, бүхий л түвшинд охид, эмэгтэйчүүдийг дэмжих, эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх томоохон сорилт тулгарсаар байна.

Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх нь хөгжлийн ахиц дэвшлийн хөдөлгөгч хүч болдог ч нийгэм, эдийн засаг, улс төр дэх тэгш бус байдал болон жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт зэргээс шалтгаалан эмэгтэйчүүд чадавх, потенциалгаа бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.

Тогтвортой хөгжлийн зорилт 5 нь эмэгтэйчүүдийн амин чухал оролцоо болон тогтвортой хөгжлийн бүхий л чиглэл дэх тэгш оролцоо, манлайллын шаардлага хэрэгцээг онцолсон байдаг. Энэхүү зорилго руу хүрэх замналд ахиц дэвшил гаргахын тулд тус чуулга уулзалт нь Стэнфордын Их сургууль, Эва Эмэгтэйчүүдийн Их сургууль болон Зүүн хойд, Төв Ази, Зүүн Өмнөд, Өмнөд Азийн орнуудын төлөөлтэйгээр зохион байгуулагдаж байгаа билээ.

Нийгмийн амьдралын бүхий л салбарт эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлж, шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш боломж, тэгш оролцоог хангах нь хөгжлийн зорилго төдийгүй, хөгжилд хүрэх чухал хэрэгсэл гэж ойлгож болно.

Жендэрийн тэгш байдал хангагдахгүй, эмэгтэйчүүдийн төлөөлөл, оролцоо байх ёстой түвшингээс доогуур байх нь эдийн засаг утгаараа алдагдсан боломжийн өртгийг нэмэгдүүлж байгаа хэрэг юм. Өөрөөр хэлбэл, ашиглах ёстой нөөцөө дутуу, доогуур түвшинд ашиглах нь алдагдлыг нэмэгдүүлдэг. Улмаар гацаанд орсон олон асуудал шийдлээ олохгүй үлдэх, эсвэл хэт өндөр зардлаар шийдэх зэрэг сөрөг нөлөө, үр дагаврыг бий болгодог.

Азид хийсэн судалгаагаар Азийн хэд хэдэн оронд охидуудын чанартай боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хомс байхын зэрэгцээ эмэгтэйчүүдэд зохистой ажил эрхлэх, түүндээ таарсан зохимжтой цалин авах боломж хязгаарлагдмал байна. Цаашлаад улс төр, эдийн засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, институц дэх төлөөлөл ч бага байна.

Монгол улс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, шударга ёсыг 1924 оны үндсэн хуулиндаа тунхагласан **Ази тивийн анхны улс** юм. Өнгөрсөн зуунд дэлхий дахинаа эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийг чухалаар тавьж шийдэж ирсэн бол энэ зуун нь бүх нийтийн тэгш эрх, тэгш боломж тэр дундаа хөгжилд эмэгтэйчүүдийн үүрэг ролийг чухалчилсан ийм эрин үе болж байна.

Дэлхийн хөгжлийн тайланд дурдсанаар Монгол Улсад 1990 онд шийдвэр гаргах түвшин буюу Ардын их хуралд эмэгтэйчүүдийн төлөөлөл 25 хувьтай байсан бол өнгөрсөн 30 жилийн хугацаанд энэ төлөөлөл 30 гаруй хувиар буурсан байна.

Өнөөдөр Монгол Улсын төрийн, улс төрийн албан тушаалтнуудын жендэрийн байдлыг авч үзвэл Монгол Улсын Их Хурлын гишүүдийн **17.1 хувь**, Засгийн газрын гишүүдийн **13.6 хувь**, Дэд сайд нарын **6.2 хувь**, Аймгийн засаг дарга нарын **4.7 хувь**, Дүүргийн засаг дарга нарын **11.1 хувь** эмэгтэйчүүд байгаа нь дэлхийн парламентын засаглалтай ардчилсан улс орнуудтай харьцуулахад маш доогуур үзүүлэлт юм (**тоог нь нягтална уу**).

Тэгвэл дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүдийн парламентын төлөөлөл 1990 оныг 2020 онтой харьцуулахад **өндөр орлоготой орнуудад 2 дахин, бага болон дунд орлоготой орнуудад 60 гаруй хувиар нэмэгдсэн** байна. Өөрөөр хэлбэл, дундаас дээш орлоготой эдийн засгуудад эмэгтэйчүүдийн эдийн засаг, улс төрийн оролцоо өссөн байна.

Монгол улс 1961 онд НҮБ-д элссэнээс хойш жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой олон улсын конвенц, гэрээ хэлэлцээрт нэгдэж, соёрхон баталсан. 1996 онд “**Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр**”-ийг санаачилж, 2000 онд Жендэрийн тэгш байдлын асуудал хариуцдаг Үндэсний зөвлөлийг байгуулж, тус зөвлөл нь 2005 он хүртэл “**Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр**”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байв. 2005 оноос Жендэрийн тэгш байдлын Үндэсний Хороог байгуулж үйл ажиллагаа нь өргөжсөн.

Монгол Улсын Засгийн газар Жендэрийн тэгш байдлыг хангах, хүний эрх, ялангуяа эмэгтэйчүүд, охидын эрхийг хамгаалахын төлөө **Жендэрийн тэгш байдлыг хангах хөтөлбөрийг** 2003-2015 онд хэрэгжүүлсэн бөгөөд энэ хугацаанд “**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004)**”, “**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)**”, “**Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2011)**”, “**Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)**” зэрэг хэд хэдэн хуулийг УИХ-аар батлуулж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүй, бодлогын орчинг бүрдүүлсэн.¹

Манай улсад жендэрийн тэгш байдлыг хангаж, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх суурь зохицуулалтыг тусгасан **10 гаруй хууль, 5 бодлогын баримт бичиг** байдаг ч тэдгээр хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилт төдийлэн хангалтгүй байгаа нь жендэрт суурилсан тэгш бус байдал өндөр байгаагаар нотлогддог.

Дэлхийн дундажаар их, дээд сургууль төгсөөд 10 жил болсон, ахисан түвшний боловсролтой эмэгтэй ижил түвшний боловсролтой эрэгтэйтэй харьцуулахад **23 хувиар бага** цалин хөлс авдаг. Монгол Улсад эмэгтэйчүүдийн

¹ “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн Газар., 2017-2021

цалин нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад **17 хувь доогуур** байна. Энэ нь эрчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн дээд болон ахисан түвшний боловсрол эзэмшсэн байдал нэлээд өндөр байдагтай холбоотой байна.

Статистикийн тоон мэдээллээр, манай улсын эрүүл мэндийн салбарын 80 гаруй, боловсролын салбарын 70 гаруй, банк санхүү, даатгалын салбарын 70 орчим, жижиглэн худалдаа, засвар үйлчилгээний салбарын 60 орчим, хөнгөн үйлдвэрлэлийн 50 гаруй хувь нь эмэгтэй ажиллагсад байна. 2022 оны эцсийн байдлаар манай улсад **140** гаруй мянган аж ахуйн нэгж бүртгэлтэйгээс 64 орчим хувь нь эрэгтэй, **36 орчим хувь нь эмэгтэй** удирдлагатай байна.

Харин, өмч, хөрөнгө эзэмшиж байгаа байдлыг авч үзвэл, орон сууц өмчлөлөөр Монгол эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс **2 дахин бага**, газар эзэмшлийн хувьд **3-6 дахин бага**, бусад үл хөдлөх хөрөнгө эзэмшлийн хувьд **1.5 дахин бага** байна.

Манай улсад дээд боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдийн тоо өндөр ч хөдөлмөрийн зах зээлд тэдний оролцоо буурч байна. Ялангуяа 25-аас 34 насны эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин харьцангуй буурсан дүнтэй байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин манай улсад 2006 оноос хойш буурч байгаа бөгөөд цар цахлын үед хамгийн доод түвшин буюу 50 хувиас бага болсон². 2022 оны эцэст Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний оролцооны түвшин, эмэгтэйчүүдийнх **52 хувь**, харин эрэгтэйчүүдийнх **68 хувьтай** байв. Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин дундажаар **60 гаруй хувьтай** байгаа нь 100 хүн тутмын ердөө 60 нь ажиллах сонирхолтой байгаа бол эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн ажиллах сонирхол даруй **17 орчим пунктээр** доогуур байгаа нь анхаарал хандуулах хэрэгтэй юм. **(тоог нягтална уу)**

Монгол Улс эдийн засгийн хөгжлөө эрчимжүүлж гэвэл эмэгтэйчүүдийн эдийн засаг, нийгэм, улс төрийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх, тэднийг дэмжих зайлшгүй шаардлагатай. Тухайлбал, Монгол Улсад эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшинг **65%**³ хүртэл нэмэгдүүлж чадвал нэг талаас, өрх гэр, бизнес, ажлын байран дахь жендэрийн тэгш байдлыг сайжруулна, нөгөө талаас нэг хүнд ногдох ДНБ-ийг өсгөх боломжтой тооцоо бий.⁴

Монгол Улсын Засгийн газраас 2022 онд **“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)”**-г батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд дараах 5 зорилтыг тавин ажиллаж байна. Үүнд: (1) Охид, хөвгүүд, эрэгтэй, эмэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлэх; (2) Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш боломж,

² 2021 оны урьдчилсан тоон мэдээллээр эмэгтэй ажиллах хүчний оролцооны түвшин 49.9 хувь болж буурсан (ҮСХ)

³ Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 52 хувь (ҮСХ., 2021)

⁴ Азийн хөгжлийн банк, 2022

жендэрийн тэгш оролцоог дэмжих; (3) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тогтолцоог хөгжүүлэх; (4) Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх; (5) Уур амьсгалын өөрчлөлтүүдийг сааруулах, дасан зохицоход жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр ажиллаж байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратегийн дээрх зорилтыг амжилттай, тууштай хэрэгжүүлж, эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гаргаж ажиллах шаардлагатай байна.

Жендэрийн тэгш байдал нь зөвхөн хүйсийн асуудал биш, энэ нь улс орны хөгжил, дэвшлийн асуудал юм.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аливаа асуудалд хандаж байгаа байдал, шийдэж байгаа арга барилаараа ялгаатай байдаг. Эрэгтэйчүүд шийдэж чадахгүй гацаанд орсон олон асуудлыг эмэгтэйчүүдийн дэмжлэгтэйгээр шийдэж чаддаг. Эрчүүд асуудлыг олонхоороо хүч түрэн шийдэхийг оролддог, энэ нь заримдаа гацаанд ордог, харин эмэгтэйчүүд асуудлыг эв зөийг олж, хэлцэл хийх, зөвшилцөх замаар шийдэхийг чухалчилдаг. Эмэгтэйчүүд өөрийнхөө өмнөөс, өөрийгөө төлөөлж хэлцэл хийхдээ ч гэсэн нийтийн эрх ашиг, нийгмийн төлөө байдаг.

Улс орны үндэсний болон орон нутгийн удирдлагын түвшинд эмэгтэйчүүд ажилласнаар авилгын түвшин хамгийн бага байж, шударга байдал нэмэгддэг болохыг дэлхийн олон оронд хийгдсэн судалгаанууд харуулдаг. Эмэгтэйчүүд хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал зэрэг нийгмийн дэд бүтцийн салбарт амжилттай ажиллаж байна гэж өнгөрсөн 30 жилд ярьж байсан бол сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд эмэгтэйчүүдийн удирдсан маш олон шинэ салбар гарч ирж байна. Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн, шинэ менежментийн салбарт ч гэсэн эмэгтэйчүүд олноороо ажиллаж байна.

Дэлхийн томоохон судалгааны байгууллага МакКинси судалгаагаар эрчүүдийг ур чадварыг нь харгалзан албан тушаалд дэвшүүлдэг бол эмэгтэйчүүдийг гаргасан амжилт, туршлага дээр нь үндэслэн албан тушаалд дэвшүүлдэг. Амжилт олох хийгээд, бусдад аятай сэтгэгдэл төрүүлэх нь эрчүүдэд шууд хамааралтай, харин эмэгтэйчүүдэд урвуу хамааралтай байдаг. Дээр нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломж, санхүүгийн чадамж эрчүүдтэй харьцуулахад тааруу байдаг. Иймд эмэгтэй хүн эрчүүдтэй өрсөлдөхийн тулд дор хаяж 2 дахин илүү хичээл зүтгэл, чармайлт гаргахын дээр, илүү хүнд бартаатай замыг туулдаг. Тиймээс эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэхэд нийгмийн уламжлалт, соёлын, зан заншлын, эдийн засгийн саад бэрхшээлийг тооцож, бууруулах арга замыг эрэлхийлж ажиллах хэрэгтэй байна.

Дэлхийн дэвшилтэт улс орнууд өнөөдөр ардчилалын сонгодог хэлбэр болох төлөөллийн ардчилалыг сонгуулийн зарчимд ашиглаж байна. Төлөөллийн ардчилалын үндсэн гол шинжүүр нь эх олонлогоо төлөөлж байх чадвар юм. Монгол Улсын хүн амын ч тэр, сонгогчдын ч тэр 50-иас илүү хувь нь эмэгтэйчүүд. Тиймээс хүн амын зохистой, тэнцвэртэй төлөөллийг хадгалах нь хөгжлийн томоохон сорилт.

#ҮХНӨ, Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийн талаар оруулах

Эдүгээгээс 40 орчим жилийн өмнө Норвегийн Ерөнхий сайд, Хөдөлмөрийн намын дарга асан, хатагтай Гро Харлем хэлэхдээ: ***“Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл гуравны нэг буюу 33 хувь байх ёстой. Энэ бол бодлогод нөлөөлөх, улс төр хийх зайлшгүй нөхцөл. Гэхдээ, хангалттай нөхцөл бол биш. Эмэгтэйчүүдийн оролцоо 30 хувиас бага байх нь бодлогод нөлөөлөх, улс төр хийх боломжийг үгүй хийдэг.”*** гэжээ.

Улс орны эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийн төлөөлөл, манлайллыг нэмэгдүүлэх нь үнэ цэнтэй, чухал бөгөөд зайлшгүй юм.